



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/16

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2016 оны А/151 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Цахим аймаг хөтөлбөр" /Видео хурлын тоног төхөөрөмж/ ДУХАА/2016/039 гүйцэтгэгчээр "Монтел" ХХК - ыг сонгон 36,872,000 /гучин зургаан сая найман зуун далан хоёр мянган/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Цахим аймаг хөтөлбөрийн /Видео хурлын тоног төхөөрөмж/ тоног төхөөрөмжийг тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд нийлүүлэн хүлээлгэн өгөхийг "Монтел" ХХК-ний захирал /Д.Гансүх/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга /М.Цогзолмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0300027